Хүснэгт № 2. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Ажиллагчидтай холбогдсон авлага	3,516.0	-	(3,516.0)	
Хувь хүмүүст олгосон зээл	181,713.7	212,147.2	30,433.5	
Дүн	185,229.7	212,147.2	26,917.5	


Эх сурвалж: Жаргалант сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт авлагын үлдэгдэл болох 212,147.2 мянган төгрөг нь Хоршоо хөгжүүлэх сангийн иргэдэд олгосон зээлийн авлага байна.

Хүснэгт № 3. Авлагын үлдэгдэл байгууллагаар

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Засаг даргын Тамгын газар	16.0	0.0	-16.0	0.0
ИТХ	3,500.0	0.0	-3,500.0	0.0

Аудитын код: БНА-2025/001/НА-СТА-ТТЗ



Жаргалант сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

СХС	181,713.7	212,147.2	30,433.5	100.0
НИЙТ ДҮН	185,229.7	212,147.2	26,917.5	100.00

Эх сурвалж: Жаргалант сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд ЗДТГ болон ИТХ-ын авлага бүрэн барагдаж, Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн авлага 30,433.5 мянган төгрөгөөр буюу 16.7 хувиар өссөн байна.

3.5.3 Бараа материал

Тайлант оны бараа материал дансны эцсийн үлдэгдэл 270,345.8 мянган төгрөг болж өмнөх оноос 117,840.0 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 4. Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/ Өсөлт (+), Бууралт (-)	
Бичиг хэргийн материал	2,865.6	3,116.1	250.5	
Аж ахуйн материал	46,115.7	53,889.7	7,774.0	
Нөөцийн бараа	0.0	24,450.0	24,450.0	
Барилгын засварын материал	390.8	390.8	0.0	
Бусад хангамжийн материал	56,946.5	142,313.0	85,366.5	
Мал амьтад	46,186.3	46,186.3	0.0	
Дүн	152,504.8	270,345.8	117,841.0	

Эх сурвалж: Жаргалант сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын дансны үлдэгдэл 270,345.8 мянган төгрөг болж 117,841.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд ЗДТГ-ын бусад хангамжийн материал 93,946.3 мянган төгрөгөөр буюу 64.5 хувиар өссөн нь голлох нөлөөг үзүүлжээ.

Хүснэгт № 5. Бараа материалын үлдэгдэл байгууллагаар

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
ИТХ	7,055.5	6,500.2	(555.3)	2.4
ОНХС	-	24,450.0	24,450.0	9.0
ЗДТГ	145,449.3	239,395.6	93,946.3	88.6
НИЙТ ДҮН	152,504.8	270,345.8	117,841.0	100.0

Эх сурвалж: Жаргалант сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд нийт нэмэгдсэн 399,332.8 мянган төгрөгийн бараа материалаас 245,109.8 мянган төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр, 154,223.0 мянган төгрөгийн бараа материалыг хандиваар үнэ төлбөргүй хүлээн авсан байна. Мөн нийт хасагдсан 281,491.8 мянган төгрөгийн бараа материалаас 268,761.8 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан, 12,730.0 мянган төгрөгийн бараа материалыг данснаас хассан байна.

Хүснэгт № 6. Бараа материалын орлого, зарлагын төрөл

Нэмэгдсэн	399,332.8	Хасагдсан	281,491.8
Худалдан авсан	245,109.8	Худалдсан, зарцуулсан	268,761.8
Хандиваар	154,223.0	шилжүүлсэн	0.0
бусад	0.0	бусад	12,730.0

Эх сурвалж: Жаргалант сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.5.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгө дансны эцсийн үлдэгдэл 3,064,084.6 мянган төгрөг болж оны эхний үлдэгдлээс 729,394.3 мянган төгрөгөөр буюу 31.2 хувиар өссөн байна.

Хүснэгт № 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
БИЕТ ХӨРӨНГӨ	2,231,678.3	2,961,072.6	729,394.3	89.6
Барилга байгууламж, орон сууц	899,994.0	919,994.0	20,000.0	30.0
Тээврийн хэрэгсэл	199,800.8	350,751.1	150,950.3	11.4
Машин тоног төхөөрөмж	312,266.7	403,297.0	91,030.3	13.2
Тавилга эд хогшил	109,438.9	129,774.0	20,335.1	4.2
Зам гүүрийн барилга	214,620.0	214,620.0	0.0	7.0
Бусад үндсэн хөрөнгө	495,557.9	942,636.5	447,078.6	30.8
БИЕТ БУС ХӨРӨНГӨ	103,012.0	103,012.0	0.0	3.4
Программ хангамж	200.0	200.0	0.0	0.0
Бусад биет бус хөрөнгө	102,812.0	102,812.0	0.0	3.4
НИЙТ ДҮН	2,334,690.3	3,064,084.6	729,394.3	93.0

Эх сурвалж: Жаргалант сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдлийн 99.2 хувийг Засаг даргын тамгын газар, 0.8 хувийг Иргэдийн төлөөлөгчдийн хурал эзэлж байна.

Хүснэгт № 8. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл байгууллагаар

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
ИТХ	24,902.9	16,413.8	-8,489.1	0.8
ЗДТГ	2,309,787.4	1,989,621.7	-320,165.7	99.2
НИЙТ ДҮН	2,334,690.3	2,006,035.5	-328,654.8	100.0

Эх сурвалж: Жаргалант сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд үндсэн хөрөнгө данс 729,394.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь төсвийн хөрөнгөөр тус сумын ЗДТГ 43,067.5 мянга, ИТХ 4,972.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан, хандив тусламжаар ЗДТГ 759,508.0 мянга, ИТХ 3,377.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авсан байна. Харин 81,530.8 мянган төгрөгөөр хасагдсан нь Баянхонгор аймгийн ИТХ-ын 2024 оны 2/13-р тогтоолын дагуу ЗДТГ-ын нийт акталсан хөрөнгө эзэлж байна.

Хүснэгт 9. Үндсэн хөрөнгийн орлого, зарлагын төрөл

	Нэмэгдсэн	Хасагдсан	
	810,925.1		81,530.8
Худалдан авсан	48,040.1	0	0
Хандиваар	762,885.0	81,530.8	81,530.8

Эх сурвалж: Жаргалант сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.5.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 5,613.0 мянган төгрөг байсан ба эцсийн үлдэгдэл 2,498.5 мянган төгрөг болж 3,114.5 мянган төгрөгөөр буурсан байна.

Жаргалант сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Хүснэгт 10. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР ДҮН	5,613.0	2,498.5	-3,114.5	100.0
Ажилчидтай холбогдсон өглөг	113.0	-	(113.0)	-
Байгууллагад төлөх өглөг	5,500.0	2,498.5	(3,001.5)	100.0
Дүн	5,613.0	2,498.5	(3,114.5)	100.0

Эх сурвалж: Жаргалант сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд өр төлбөрийн эцсийн үлдэгдэл 2,498.5 мянга болж эхний үлдэгдлээс 3,114.5 мянган төгрөгөөр буурсан нь цахилгааны үнэ нэмэгдсэнтэй холбоотой ЕБС-ийн 2,498.5 мянган төгрөгийн өглөг байна.

Хүснэгт № 11. Нийт өр төлбөрийн үлдэгдэл байгууллагаар

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
ЗДТГ	101.0	-	(101.0)	-
ЕБС	-	2,498.5	2,498.5	100.0
ОНХС	5,500.0	-	(5,500.0)	-
ИТХ	12.0	-	(12.0)	-
ДҮН	5,613.0	2,498.5	(3,114.5)	100.0

Эх сурвалж: Жаргалант сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.5.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 3,666,193.7 мянган төгрөг байсан ба эцсийн үлдэгдэл 4,082,541.3 мянган төгрөг болж, 416,347.6 мянган төгрөгөөр төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 12. Засгийн газрын хувь оролцоо

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	547,324.9	547,324.9	-	19.2
Хуримтлагдсан үр дүн	1,554,218.6	2,220,885.3	666,666.7	77.7
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	89,828.4	89,828.4	-	3.1
Дүн	2,191,371.9	2,858,038.5	666,666.7	100.0

Эх сурвалж: Жаргалант сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 666,666.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.7 Орлогын данс

Сумын ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн хуралдаанаар 14/25 дугаар тогтоолоор сумын төсвийн татварын орлогыг 442,384.0 мянга, хүү торгуулийн орлогыг 10,000.0 мянгаар нийт 452,384.0 мянган төгрөгөөр баталсан ба сумын ИТХ-ын 2024 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 19/14 дүгээр тогтоолоор татварын орлогыг 199,271.2 мянган төгрөгөөр нэмж тодотгосон байна.

Хүснэгт №13. Төвлөрүүлэх орлого

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1.Татварын орлого	641,655.2	720,887.2	79,232.0	112.3
ЦХТА орлого /суутган/	269,000.0	311,045.9	42,045.9	115.6
Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	2,100.0	1,959.2	(140.8)	93.3
Бууны татвар	6,960.0	7,755.0	795.0	111.4
ИОТХ	102,400.0	109,199.1	6,799.1	106.6
Улсын тэмдэгтийн хураамж	6,700.0	9,300.5	2,600.5	138.8
Хадгаламжийн хүүгийн орлого	43,800.0	54,085.3	10,285.3	123.5
Үл хөдлөх хөрөнгө худалдан борлуулсаны орлого	2,500.0	4,450.4	1,950.4	178.0
Малд ногдуулах албан татвар	7,591.2	8,475.1	883.9	111.6
Газрын төлбөр	4,400.0	4,380.0	(20.0)	99.5
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	6,936.0	3,404.2	(3,531.8)	49.1
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	187,768.0	205,332.5	17,564.5	109.4
ТТАМАТөлбөр	1,500.0	1,500.0	-	100.0
2.Татварын бус орлого	10,000.0	10,235.8	235.8	78.8
2.1.Хүү торгуулийн орлого	10,000.0	7,883.2	(2,116.8)	78.8
2.2 Газрын дуудлага худалдааны орлого	-	1,232.6	1,232.6	
2.3 Төсөвт байгууллагын өөрийн орлого	-	1,120.0	1,120.0	
Нийт дүн	651,655.2	731,123.0	79,467.8	112.2

Эх сурвалж: Жаргалант сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Сумын төсөвт төвлөрөх татварын орлогыг 112.3 хувь буюу 79,232.0 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн байна. Үүнээс цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого 42,045.9 мянга, ИОТХ 6,799.1 мянга, хадгаламжийн хүүний орлого 10,285.3 мянга, бууны татвар 795.0 мянга, улсын тэмдэгтийн хураамж 2,600.5 мянга, ҮХЭХ борлуулсны орлого 1,950.4, малд ногдуулах албан татвар 883.9 мянга, ан амьтны нөөц ашигласны төлбөр 17,564.5 мянган төгрөгөөр давуулан биелсэн нь голлох нөлөөг үзүүлсэн байна.

Төсөвт төвлөрөх татварын бус орлогод төлөвлөөгүй орлого болох газрын дуудлага худалдааны орлого 1,232.6 мянга, төсөвт байгууллагын өөрийн орлого

1,120.0 мянган төгрөг төвлөрч, гүйцэтгэлээр 235.8 мянган төгрөгөөр давуулан биелсэн байна.

3.8 Зардлын данс

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 70105, 70106, 70503, 71602, 71702, 71801, 71802, 72101 гэсэн кодтой 8 хөтөлбөрт зориулан 2,477,617.5 мянган төгрөгийн төсөв батлагдаж, 2,149,504.09 мянган төгрөгийг гүйцэтгэлээр зарцуулж тайлант оны төсвийн гүйцэтгэлийн зардлын дүн 86.8 хувь байна.

3.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.9.1 Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн харьяаны 5 төсвийн байгууллага төсвийн төслийг бэлтгэж, аймгийн СТСХ-т хүргүүлсэн бөгөөд сумын ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 14/25 дугаар тогтоолоор нийт 2,280,215.4 мянган төгрөгийг баталсан ба сумын ИТХ-ын 2024 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 19/14 дугаар тогтоолоор 197,402.1 мянган төгрөгийг нэмж тодотгосон байна.

Хүснэгт №14. Төсвийн төлөвлөлт байгууллагаар

Орлогын төрөл	Төсвийн төсөл	Анх батлагдсан төсөв	Зөрүү
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	183,679.6	201,252.20	-17,572.6
Засаг даргын Тамгын газар	806,350.6	1,088,759.60	-282,409.0
Сургууль	153,856.0	156,252.90	-2,396.9
Цэцэрлэг	48,660.5	49,300.20	-639.7
Эрүүл мэндийн төв		56,070.90	-56,070.9
Соёлын төв	83,115.4	99,573.90	-16,458.5
Сум хөгжүүлэх сан		157,456.90	-157,456.9
Орон нутгийн хөгжлийн сан		471,548.70	-471,548.7
Нийт дүн	1,275,662.1	2,280,215.3	-1,004,553.2

Эх сурвалж: Жаргалант сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.9.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрийн арга хэмжээний зардалд сумын ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн хуралдааны 14/25 дугаар тогтоолоор анх 2,280,215.4 мянган төгрөгөөр баталсан бөгөөд 2024 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 19/14 дугаар тогтоолоор 197,402.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 2,477,617.5 мянган төгрөг баталжээ.

Нийт зардлын 304,185.8 мянган төгрөгийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох санхүүжилтээс, 876,676.5 мянган төгрөгийг санхүүгийн дэмжлэгээс, орон нутгийн өөрийн орлого 651,655.2 мянга, сум хөгжүүлэх сангийн эргэн төлөлтийн орлого 93,956.9 мянга, төсөвт байгууллагын өөрийн орлого 1,000.0 мянга, төсвийн

Жаргалант сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

урьд оны үлдэгдэл 494,470.1 мянга, ОНХС-ийн өвсний орлого 55,673.0 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн болон санхүүгийн дэмжлэгээс авах санхүүжилтээс 1,951,383.4 мянга, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 98,504.4 мянга, нийт 2,049,887.8 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлэн 143,076.6 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт №16. Төсвийн гүйцэтгэл байгууллагаар

Байгууллагын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь	ОН
ЗДТГ	1,226,380.1	1,104,731.1	121,649.0	90.1	121,748.9
ИТХ	210,299.9	190,447.1	19,852.8	90.6	19,862.7
Соёлын төв	99,573.9	99,082.8	491.1	99.5	491.1
Сум хөгжүүлэх сан	161,209.7	70,528.0	90,681.7	43.7	-
Сургууль	157,932.9	157,928.1	4.8	100.0	4.8
Цэцэрлэг	50,100.2	49,141.4	958.8	98.1	958.8
ЭМТ	56,070.9	56,059.8	11.1	100.0	1.1
ОНХС	516,049.9	421,585.8	94,464.1	81.7	-
Нийт дүн	2,477,617.5	2,149,504.1	328,113.4	86.8	143,077.5

/мянган төгрөг/

Эх сурвалж: Жаргалант сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,149,504.1 мянган төгрөг буюу 86.8 хувьтай байгаа нь ЗДТГ-ын урсгал зардлыг 121,649.0 мянга, ИТХ-ын урсгал зардлыг 19,852.8 мянга, орон нутгийн хөгжлийн сангийн зардлыг 94,464.1 мянга, хоршоо хөгжүүлэх сангийн зардлыг 90,681.7 мянга, соёлын төвийн тогтмол зардлыг 491.1 мянга, ЕБС-ийн тогтмол зардлыг 4.8 мянга, цэцэрлэг 958.8 мянга, эрүүл мэндийн төвийн тогтмол зардлыг 11.1 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн нь нөлөөлжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.9.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсвийн захирагчаас хуваарилсан 53,706.9 мянган төгрөг, төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлого 62,694.5 мянган төгрөг нийт 116,401.4 мянган төгрөгийн орлого төвлөрснөөс бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжид 61,161.3 мянга, бараа үйлчилгээний бусад зардалд 2,681.9 мянга, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэгт 50,025.0 мянган төгрөг, орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох шилжүүлэгт 2,533.2 мянган төгрөгийн тус тус зарцуулсан байна.

Хүснэгт 16. Нэмэлт санхүүжилтийн дансны судалгаа /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	ИТХ	ЗДТГ	НИЙТ
НИЙТ ОРЛОГО	10,822.0	105,579.4	116,401.4

Жаргалант сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,822.0	42,884.9	53,706.9
Төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.0	62,694.5	62,694.5
НИЙТ ЗАРЛАГА	10,822.0	105,579.4	116,401.4
Бараа үйлчилгээний бусад зардал	0.0	2,681.9	2,681.9
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,000.0	60,161.3	61,161.3
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	9,822.0	40,203.0	50,025.0
Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох	0.0	2,533.2	2,533.2
Төсөвт төвлөрүүлсэн	0.0	0.0	0.0

Эх сурвалж: Жаргалант сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

АУДИТЫН ТАЙЛАН

4.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Жаргалант сумын Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгохтой холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор А.Адилзаяа гүйцэтгэж аудитын менежер М.Алтантуяа, Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар үе шатны хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Жаргалант сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 02 дүгээр сарын 19-ний өдрийн 2/24 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

Жаргалант сумын Засаг даргын 1 дүгээр гарын үсгийг Засаг дарга Б.Саранцэцэг, 2 дугаар гарын үсгийг санхүүгийн албаны дарга Д.Азжаргал нар зурж байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэлийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, материаллаг

буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 70 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны нийт батлагдсан төсвийн 2,477,617.5 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 24,776.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлын төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 17,343.3 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт болон Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж үр дүнг баримтжуулсан.

4.4 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим сайтад 5 сая төгрөгөөс дээш орлогын 17 гүйлгээ, зарлагын 31 гүйлгээ, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг хугацаанд нь мэдээлсэн байна.

4.5 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайланд онд Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажиллахыг бүх шатны төсөв захирагчид даалгасан. Уг хуулийн хэрэгжилтийг Жаргалант сумын Засаг даргын харьяа төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар шалгахад зөрчил илрээгүй.

4.6 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Наранцэцэг гүйцэтгэсэн ба төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар 22,638.1 мянган төгрөгийн 2 зөвлөмж хүргүүлснээс зөвлөмжийн хэрэгжилтийг 100 хувь биелүүлэн ажилласан байна.

Хүснэгт 17 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	-	-	-	-	-

Жаргалант сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Албан шаардлага	-	-	-	-	-
Зөвлөмж	2	22,638.1	2	22,638.1	100
Нийт дүн	2	22,638.1	2	22,638.1	100

4.7 Дараагийн аудитаар анхаарах асуудал
Байхгүй

4.8 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд сумын орон нутгийн нөөц хөрөнгөнд 48,601.4 мянган төгрөгөөр баталж 45,729.8 мянган төгрөгийг зарцуулж 2,871.6 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

4.9 Аудитын гол асуудал

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Жаргалант сумын Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт 138 арга хэмжээ төлөвлөж 2024 оны жилийн эцсийн хэрэгжилтийг 96.09 хувьтай дүгнэсэн байна.

Тайлант онд хэрэгжүүлэх 138 арга хэмжээнд зориулан нийт 2,477,617.5 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр нийт 2,149,504.1 мянган төгрөгийг зарцуулж 86.8 хувийн биелэлттэй байна.

Сумын ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Жаргалант сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяалагдах 2 төсвийн байгууллага, 2 тусгай сан, нийт 4 байгууллагын санхүүгийн тайлан 4 улсын төсвийн байгууллагын тогтмол зардал нэгтгэгдсэн байна

Төрийн аудитын байгууллагаас Жаргалант сумын Засаг даргын харьяа 4 байгууллагын санхүүгийн тайланг түүвэр аудитад хамруулан санхүүгийн аудитыг гүйцэтгэсэн байна.

Хүснэгт №17. Төсвийн шууд захирагчийн аудитын дүн

Байгууллагын нэр	Байгууллагын тоо				Аудитын санал дүгнэлтийн төрөл					
	Гүйцэтгэсэн				Үүнээс					
	Хамрагдвал зохиж	Хамрагдсан	Бие дааж дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Бүгд	Зөрчилгүй	Хягаарлалт тай	Сөрөг	Санал дүгнэлт өгөхөөс тагталзсан	
ЗДТГ	1	1			1					
ИТХурал	1	1			1					
ОНХС	1	1			1					
СХС	1	1			1					
НИЙТ ДҮН	4	4			4					

Эх сурвалж: Төрийн аудитын байгууллагын зөрчлийн нэгтгэл

Төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн залруулагдаагүй зөрчлийг санхүүгийн тайлангийн болон нийцлийн аудиттай



Жаргалант сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

холбоотой асуудал гэж ангилан үзсэн бөгөөд санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой 4,427.2 мянган төгрөгийн 3 зөрчил илэрсэн байна.

Хүснэгт №18. Төсвийн шууд захирагчийн алдаа зөрчлийн дүн

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн /мянган төгрөг/	Алдаа, зөрчлийн шийдвэрлэлт	Алдаа, зөрчлөлийг гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овооглол
А	2	3	4	5	6
Засаг даргын Тамгын газар		4,387.2			
1	Няравын тайланд 540,000 төгрөгийн шатахууныг орлогод аваагүй, зарлагадсан баримт байхгүй байна	540.00	Албан шаардлага	ЗДТГ-ын дарга, нягтлан бодогч	Б.Өнөрхишиг, Д.Баттөр
2	Сургуулийн захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Саранцэцэгт Баянхонгор аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны 2021.01.27-ны өдрийн 111/ШШ2021/0004 шүүхийн шийдвэрийн дагуу нийт 3,847.2 мянган төгрөгийг шилжүүлснийг авлагаар тусгаагүй.	3,847.2	Зөвлөмж	ЗДТГ-ын дарга, нягтлан бодогч	Б.Өнөрхишиг, Д.Баттөр
ОНХС		40.0			
3	Сумын Засаг даргын 2024 оны А/178 дугаар захирамжаар ОНХС-ын үйл ажиллагаанд хяналт хийсэн албан хаагчдад 400.0 мянган төгрөгийн урамшуулал олгосон ба ХХОАТ-ыг суутгаагүй байна.	40.0	Төлбөрийн акт	Засаг дарга, нягтлан бодогч	Б.Саранцэцэг, Д.Доржпагма
Нийт дүн		4,427.2			

Эх сурвалж: Төрийн аудитын байгууллагын зөрчлийн нэгтгэсэн

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 5,809.4 мянган төгрөгийн 2 зөрчил илэрсэнд 5,809.4 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 1 зөвлөмж, 1 албан шаардлага хүргүүлэв. Үүнд:

5.1 Зөвлөмж

Тайлант онд үл хөдлөх хөрөнгийн албан татвар 140.8 мянга, газрын төлбөр 20.0 мянга, хог хаягдлын хураамж 3,531.8 мянга, хүү торгуулийн орлого 2,116.8 мянган төгрөгөөр тус тус орлогын төлөвлөгөө тасарсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл 5.1 дэх “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална”, 5.1.1 дэх “Жинхэнэ хэрэгжилтийн”, УСНББОУС 23 Арилжааны бус ажил гүйлгээний орлого (татвар ба шилжүүлэг), НББОУС 18 Орлого, МНС-6817-4:2020 стандартын 5.2.1.7.2 Иж бүрэн байх-санхүүгийн тайланд өгөх дүгнэлтэд нөлөөлж болзошгүй гүйлгээ, үйл явдал, дансны үлдэгдэл, тодруулгыг орхигдуулалгүй тусгасан байх стандартууд болон Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн орлого, зарлагыг төлөвлөлийн үндэслэлтэй төлөвлөж зарцуулах зөвлөмж хүргүүлэв.

5.2 Албан шаардлага

Сумын ИТХ-аар төсөв батлахдаа Жаргалант сумын төсвийн захирагч нарын хэрэгжүүлэх хөтөлбөр хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийг баталж байгаа боловч Жаргалант сумын Засаг даргын 2024 оны

Жаргалант сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг ирүүлэхдээ Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь хэсэгт заасан бүрэлдэхүүн хэсгээр тайланг ирүүлээгүй.

Энэ нь төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь “Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна.”, 54.5.4 дэх “Хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга/хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид ТТЗ-ын санхүүгийн тайланг ирүүлэхдээ “Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5”-д заасан бүрэлдэхүүн хэсгээр ирүүлэх, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлант онд үл хөдлөх хөрөнгийн албан татвар 140.8 мянга, газрын төлбөр 20.0 мянга, хог хаягдлын хураамж 3,531.8 мянга, хүү торгуулийн орлого 2,116.8 мянган төгрөгөөр тус тус орлогын төлөвлөгөө тасарсан байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл 5.1, 5.1.1, УСНББОУС 23 Арилжааны бус ажил гүйлгээний орлого (татвар ба шилжүүлэг), НББОУС 18 Орлого, MNS-6817-4:2020 стандартын 5.2.1.7.2 Иж бүрэн байх-санхүүгийн тайланд өгөх дүгнэлтэд нөлөөлж болзошгүй гүйлгээ, үйл явдал, дансны үлдэгдэл, тодруулгыг орхигдуулалгүй тусгасан байх стандартууд болон Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.	1	5,809.4					1	5,809.4
Сумын ИТХ-аар төсөв батлахдаа Жаргалант сумын төсвийн захирагч нарын хэрэгжүүлэх хөтөлбөр хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийг баталж байгаа боловч Жаргалант сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг ирүүлэхдээ Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь хэсэгт заасан бүрэлдэхүүн хэсгээр тайланг ирүүлээгүй.	1				1	-		
Дүн	1	5,809.4			1	-	1	5,809.4

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

-----oOo-----